



Г “МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингалтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024 · 07 · 03 № 01 / 1273
танай —ны № —т

Г Тендерийн баримт бичиг
хянасан тухай

Танай газраас зарласан “LIEBHERR R976 Litronic экскаваторын сэлбэг” МРЦМ/20240102126 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Универсал Жойнт” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 20.1-д “Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”, оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчтай байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг; чанарын гэрчилгээ” гэж заасан байна.


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж, мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн A/258 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д “Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: [“Тийм” эсхүл “Үгүй” гэж бичих.], оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг” гэж заасан байна.

Захиалагч нь тендерийн баримт бичгийн ТШЗ 20.1-д заасан шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн A/258 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулсан байх тул Төрийн

0002794

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.



ДАРГА

Б.БИЛГҮҮН